



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 15 өдөр

Дугаар A/319

Булган сум

Г Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх хэсэг, Дайчилгааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх зүйл, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2025 оны мянган/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгт бэлтгэх ажлыг хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Наранбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан ўргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Г.Мөнхбат (Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн захирагч, Хурандаа)

Д.Баасанжаргал (Авто тээврийн үндэсний төвийн Булган аймаг дахь салбарын дарга)

Н.Пүрэвсайхан (Булган аймгийг Политехникийн коллежийн захирал)

Н.Төмөр-Очир (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Тоо бүртгэлийн ахлах офицер, Дэд хурандаа )

Ц.Цэрэнтогтох (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Дайчилгааны офицер, Хошууч)

Б.Намнансүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалтын, бэлтгэл сургалтын офицер, Дэд хурандаа)

Нарийн бичгийн дарга: Т.Нямхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, Дэд хурандаа)

2. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгт холбогдох чиглэлээр үзлэгт бэлтгэн шалгуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Д.Наранбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ajmal 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010458